



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 282

Мандалговь

**Хөрөнгө худалдах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйл, 77 дугаар зүйлийн 77.2, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.8."а" дахь заалтуудыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

- 1. Олгойн говийн цэвэр усны шугамын шинэчлэх үед гарсан хуучин ган хоолойн худалдан авагчаар шалгарсан Ариунболор ХХК-ний хүсэлтийг харгалзан үзэж, олгойн говийн хуучин цэвэр усны шугамын 21200 метр ган хоолойг хавсралтын дагуу хаягдал төмрийн үнээр тооцож, худалдахыг зөвшөөрсүгэй.
- 2. Ариунболор ХХК-ний ган хоолойн үнэд урьд нь төлсөн 131'000'000 /нэг зуун гучин нэгэн сая/ төгрөгийг нийт төлбөрт оруулан тооцож, нийт төлбөрийн үлдэгдэл 2'560'000 /хоёр сая таван зуун жаран мянга/ төгрөгийг 2015 оны 1-р улиралд багтаан төлүүлсүгэй.
- 3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж,хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн алба /П.Очирбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.БУДЖАВ

Аймгийн ИТХГ-ийн 2014 оны ... сарын  
... өдрийн ...-р тогтоолын хавсралт



Ган хоолойг худалдах үнэлгээ

Хөрөнгийн нэр	Тоо, хэмжээ (м)	Нэг м труба ны жин (кг)	Нийт тоо хэмжээ (кг)	Хаягдал төмрийн үнэ (кг/төг)	Худалдах үнийн санал (төг)
Ган хоолой	21'200	31,5	667'800	200	133'560'000